



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 08 дугаар сарын 26
№34 (1379)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 211. | Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай | Дугаар 89 | 1687 |
| 212. | Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай | Дугаар 90 | 1696 |

4950

ᠮᠠᠮᠤᠨ ᠪᠠᠭᠤᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠵᠢᠨ ᠵᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ

Мөрдүүрх Фолг_ оа Үлхл Норг᠔ оа Дооөлг᠔

ᠶ᠋ᠢᠨ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 89

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байнгын хороодын дарга нарт, мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Баасандорж/-т тус тус даалгасугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгуулах саналаа 2025 оны намрын ээлжит чуулган завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэхийг Байнгын, дэд хороонд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН



Монгол Улсын Их Хурлын 2025 оны 89 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭСЛИЙГ ЦУЛГАЛЫН ХУГАЦААНД ХИЙХ ТӨЛӨВИЙГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЦАГЛААР

ИД	Хяналт шалгалтын хэлбэр	Хяналт шалгалтын чиглэл	9 дүгээр сар			10 дугаар сар				11 дүгээр сар				12 дугаар сар							
			1 дахь 7 хоног	2 дахь 7 хоног	3 дахь 7 хоног	1 дахь 7 хоног	2 дахь 7 хоног	3 дахь 7 хоног	4 дахь 7 хоног	5 дахь 7 хоног	1 дахь 7 хоног	2 дахь 7 хоног	3 дахь 7 хоног	4 дахь 7 хоног	1 дахь 7 хоног	2 дахь 7 хоног	3 дахь 7 хоног	4 дахь 7 хоног			
1	Хууль тогтоомжийн мэдээллийг хяналт шалгах	Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлтийг хэлэлцэх.																			
		Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлтийг хэлэлцэх.																			
		Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 06 дугаар тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлт.																			
		Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 07 дугаар тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлт.																			
		Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 08 дугаар тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлт.																			
		Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлт.																			
		Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 10 дугаар тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлт.																			
		Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 11 дүгээр тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлт.																			
		Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлт.																			
		Аж үйлдвэрийн борлогч байгын өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулсан хяналт шалгах ажлын хэргийн санал, дүгнэлт.																			
Эдийн засгийн байнгын хороо																					
	Тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх																				



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төсөл;

2/“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

3/“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах Үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5/Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
6/Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд;

7/“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

8/Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;



9/Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл;

10/Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

11/Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

12/Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

13/Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

14/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

15/Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

16/Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

17/Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

18/Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

19/Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

20/Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

21/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

22/Арилжааны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

23/Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

24/“Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

25/Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

26/Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

27/Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

28/Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

29/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

30/Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

31/Нийтийн өмчийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд;

32/Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

33/Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

34/Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

35/Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;



36/Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд;

37/Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

38/“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

39/“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Баасандорж/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

Modular Folio_02 Yekle Horak 02 DocId3494

Հանրահայտություններ

00 համար

Համար 0 – 00 համար 1 և 2 համար 000

Մասնակցությունը համարվում է ընդունված
և համարվում է ընդունված

Հանրահայտությունները համարվում են ընդունված և համարվում են ընդունված
և համարվում են ընդունված

Հանրահայտությունները համարվում են ընդունված և համարվում են ընդունված

Հանրահայտությունները համարվում են ընդունված և համարվում են ընդունված

Հանրահայտությունները համարվում են ընդունված և համարվում են ընդունված

Հանրահայտությունները համարվում են ընդունված և համարվում են ընդունված

Հանրահայտությունները համարվում են ընդունված և համարվում են ընդունված

Հանրահայտությունները համարվում են ընդունված և համարվում են ընդունված

